



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

### “Дээлтэй монгол наадам-2015” арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Үндэсний их баяр наадам зохион байгуулах хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын гурвалсан гэрээ, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Монголчуудын уламжлалт соёлыг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Дээлтэй Монгол Наадам-2015” арга хэмжээг Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /М.Болортуяа/-д үүрэг болгосугай.

2. “Дээлтэй Монгол Наадам-2015” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.


3. Наадам зохион байгуулахад шаардагдах төсөв 19,999,800 /арван есөн сая есөн зуун ерэн есөн мянга найман зуу/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2015 оны 07 сарын 16 өдрийн  
1/69 тоот тушаалын хавсралт



"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ НААДАМ - 2015" АРГА ХЭМЖЭЭ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| №   | Зардлын зүйл   | Тоо хэмжээ | Нэгж зардал | Нийт зардал       |
|-----|--|------------|-------------|-------------------|
| 1.  | Фото стикер хэвлүүлэх /1x1.5м2/                                    | 11         | 26,000      | 286,000           |
| 2.  | Фото стикер хэвлүүлэх /1.4x2.94м2/                                 | 4          | 48,500      | 194,000           |
| 3.  | Фото стикер байрлуулах зардал                                      | 11         | 50000       | 550,000           |
| 4.  | Анонс хэвлүүлэх /6x12м2/   | 72         | 9900        | 712,800           |
| 5.  | Анонс самбарт байрлуулах төлбөр                                    | 5 өдөр     | 140,000     | 700,000           |
| 6.  | Урилга,  | 100        | 900         | 906,000           |
|     | Талархал,  | 300        | 1100        |                   |
|     | Мандат, уут  | 100        | 660         |                   |
|     | Зурагт хуудас, плакат  | 300        | 1400        |                   |
| 7.  | Өргөмжлөл  | 4          | 44,000      | 176,000           |
| 8.  | Баярын жагсаалд оролцогч байгууллага, хамт олонд олгох пайз самбар | 15         | 25,000      | 375,000           |
| 9.  | Телевизийн рекламн эх бэлтгэл                                      | 30сек      | 20,000      | 600,000           |
| 10. | Автобус түрээслэх зардал   | 4          | 150,000     | 600,000           |
| 11. | Шагналын сан /4 номинаци/-Шилдэг дүүрэг                            | 1          | 5,000,000   | 5,000,000         |
|     | Шилдэг монгол хос  | 1          | 300,000     | 300,000           |
|     | Шилдэг гадаад хос /гадаад оролцогч/                                | 1          | 100,000     | 100,000           |
|     | Шилдэг байгууллага   | 1          | 1,000,000   | 1,000,000         |
| 12. | Шүүгчийн цалин   | 5          | 100,000     | 500,000           |
| 13. | Урлагийн тоглолт   | 5          | 800,000     | 4,000,000         |
| 14. | Хөтлөгчийн хөлс  | 2          | 500,000     | 1,000,000         |
| 15. | Хувцас загварын үзүүлбэр   | 6          | 500,000     | 3,000,000         |
|     | <b>Нийт дүн</b>  |            |             | <b>19,999,800</b> |